



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 79

Сангиндалай

Сумын сүлд батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дүгээр заалтыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар уралдаанаас ТОГТООХ НЬ:

1. “ Мөнх тэнгэрийг бэлгэдсэн хөх өнгийн дэвсгэр дээр наран зүгт давхих эрдэнийн хүлгийг, эрт, эдүгээ, ирээдүй цагийг бэлгэдсэн, хүслийг хангагч чандмань эрдэнэтэй хослуулан, дэлгэр зуны хөрсийг бэлгэдсэн ногоон өнгийг суурилуулж, төгсөшгүй үргэлжлэх түмэн наст хээгээр хөвөөлж, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг амар мэндийн цэнхэр хадгаар сүлжин, гал голомтын бэлгэдэл улаан өнгийн дэвсгэр дээр суурилуулж, Эрдэнэдалай нутгийн нэрээр магнайлан, аз жаргалын бэлгэдэл алтан шаргал өнгөөр хүрээлсэн миний нутгийн сүлд оршвой” бэлгэдлийг агуулсан сүлдийг хавсралтаар баталсугай.

2. Сумын сүлдийг нийтэд хүртээл болгох ажлыг зохион байгуулж, сурталчлан таниулахыг сумын Засаг дарга (Б.Лхагвамандал), сумын Соёлын төвийн эрхлэгч (Ө.Эрдэнэчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн
79 дүгээр тогтоолын хавсралт

